

УЛИАСТАЙ СУМЫН 2024 ОНЫ ХӨРСНИЙ ЧАНАРЫН ТОЙМ МЭДЭЭ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу Завхан аймгийн Улиастай сумын хөрсний бохирдлыг 16 цэгээс өнгөн хөрсний дээж авч агрохимийн үзүүлэлтүүд болох хөрсний орчин, чийг, ялзмаг, аммонийн азот, нитратын азот, сульфат, фосфор болон 12 төрлийн хүнд металл тодорхойлж байна.

Агрохимийн хяналт-шинжилгээ

Хүснэгт1. Хөрсөнд агуулагдах агрохимийн үзүүлэлтүүд

Цэгийн нэр	Үзүүлэлтүүд						
	Чийг, %	Ялзмаг	pH	NH ₄ , мг/кг	NO ₃ , мг/кг	P ₂ O ₅ ,мг/кг	SO ₄ , мг/кг
Эрчим хүчний зүүн тал	2.99	2.36	8.17	124.37	13.967	64.118	32.6
МУИС-ийн урд талын авто угаалга	4.31	0.85	7.82	25.76	5.366	66.508	29.4
Улиастай зочид буудал	6.8	5.54	6.05	18.22	53.671	75.221	278.2
Гандан хийд	3.31	0.99	7.56	129.15	9.641	70.761	857.5
Баруун бүсийн худалдааны төв	16.61	3.85	7.6	39.85	33.275	89.212	89.5
Цэргийн ангийн баруун тал	4.38	2.19	8.17	77.28	6.240	62.244	55.7
Цаг Уурын ажиглалтын талбай	27.19	1.68	6.3	42.27	13.259	52.578	47.2
Шинэ хороо	8.59	7.75	6.6	17.72	52.189	57.498	1901.9
Гал командын зүүн тал	6.36	1.59	8.22	33.64	67.034	54.325	945.1
Мах комбинатын зүүн тал	21.83	5.84	8.39	72.71	17.275	86.193	210.6
Нэгдсэн эмнэлэгийн зүүн тал	7.73	3.78	7.83	30.09	31.752	92.502	120.4
Авто засварын газар	7.73	0.81	8.43	16.72	17.885	71.064	102.7
Завхан цэвэрлэх байгууламж	40.27	6.1	7.17	192.88	43.176	120.750	298.3
Уурын зуух	6.29	1.67	6.85	57.43	145.008	60.420	1494.0
Нефть бааз	3.75	3.79	6.7	10.46	12.230	95.004	2484.0
Богдын гол багийн гэр хороолол	10.81	2.97	7.73	22.34	220.460	95.405	2766.4

Хөрсний ялзмаг: Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Хөрсөнд хэдий чинээ их ялзмагтай байна, төдий чинээ ус, агаар, дулаан, физик- химийн шинж чанар нь сайн байна.




График1. Улиастай сумын хөрсний ялзмагийн агууламж хувиар, 2022 болон 2024 он

Урвалын орчин: Хөрсний урвалын орчин 6.05-8.43-ийн хооронд байна. Улиастай сумын хөрс нь хүчиллэг болон шүлтлэг орчинтой байна.




График2. Улиастай сумын хөрсний урвалын орчин, 2022 болон 2024 он

Дүгнэлт: 2022 оны 05 сарын байдлаар Улиастай сумд 7.0 мм-ийн тунадас орсон бол 2024 оны тус сарын байдлаар 17.9 мм тунадас орсон нь хөрсний үр шимт чанартай шууд хамааралтай буюу тунадасны хэмжээ ихэсэхэд хөрсөнд агуулагдаж буй үржил шимт элементүүд ихэссэн харагдаж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд хур тунадасны орох давтагдал эрчимшилийн өөрчлөлттэй холбоотойгоор хөрсний бүтэц эвдрэлд өртөн газрын гадарга ихээхэн өөрчлөгдөж байна. Шинжилгээний дүнгээс үзэхэд ялзмагийн агууламжийн хувь нь 0.36-7.75 хооронд байна. Мөн чийгийн агууламж 2.99-40.27%, сульфатын агууламж 29.5-2766.4 мг/кг, хөдөлгөөнт фосфорын агууламж 54.325-120.75 мг/кг, нитратын азотын агууламж 6.240-220.446 мг/кг, аммонийн азотын агууламж 10.46-192.88 мг/кг байна.